

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Төрийн аудитын санал, дүгнэлт.....	2
Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж	13
3.9. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	13
Менежментийн захидал.....	14
Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСАД КОВИД-19
ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ
АВАХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ”
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
С.ЭНХБОЛД ТАНАА

2021.02.25 № 07/590
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн, үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 48.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу, үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл <i>/төгрөгөөр/</i>
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	18,959,291,436.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	11,913,081,232.30
31211	Банкинд байгаа бэлэн мөнгө /Төрийн сан Хөрөнгө оруулалтын данс/	-	1,035,561,000.00
31212	Банкинд байгаа бэлэн мөнгө /Төрийн сан Үйл ажиллагааны данс/	-	65,732,293.25
31213	Арилжааны банк дахь харилцах	-	10,811,787,939.05
33	АВЛАГА	-	5,343,219.00
33500	Бусад авлага	-	5,343,219.00
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	-	7,040,866,948.95
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,040,866,948.95
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	44,744,421.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	44,744,421.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	44,346,721.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	397,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	19,004,035,857.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	19,004,035,857.25
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
51200	Хуримтлагдсан үр дүн	-	-
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-
51220	Тайлант үеийн үр дүн	-	19,004,035,857.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	19,004,035,857.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	0.00	19,099,836,106.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	19,099,836,106.61
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	19,099,836,106.61
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.00	19,027,047,535.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,744,695.84
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	0.00	19,024,302,839.41
122	Тусламжийн орлого	0.00	72,788,571.36
122002	Хандив тусламж (гадаад)	0.00	72,788,571.36
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	153,942,091.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	153,942,091.03
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	153,942,091.03
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	39,199,047.62
210101	Үндсэн цалин	0.00	39,199,047.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	4,899,880.95
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	4,899,880.95
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	11,793,638.18
210401	Бичиг хэрэг	0.00	1,017,300.00
210402	Тээвэр шатахуун	0.00	437,030.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	0.00	7,371,208.18
210404	Ном, хэвлэлийн зардал	0.00	1,850,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,118,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	98,049,534.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	97,686,640.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	362,884.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	0.00	18,945,894,015.58
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	58,141,841.67
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	58,141,841.67
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	0.00	19,004,035,857.25

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	19,099,836,106.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	19,099,836,106.61
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	19,099,836,106.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	19,099,836,106.61
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,744,695.84
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	19,024,302,839.41
122	Тусламжийн орлого	0.00	72,788,571.36
122002	Хандив тусламж (гадаад)	0.00	72,788,571.36
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	204,029,731.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	204,029,731.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	204,029,731.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	39,199,047.62
210101	Үндсэн цалин	0.00	39,199,047.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	4,899,880.95
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	4,899,880.95
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	14,293,638.18
210401	Бичиг хэрэг	0.00	2,517,300.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	1,437,030.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	7,371,208.18
210404	Ном, хэвлэл	0.00	1,850,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,118,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	45,387,640.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	44,989,940.00
210602	Тавилга	0.00	397,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	100,249,524.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	99,886,640.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	362,884.28
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	18,895,806,375.47
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	0.00	7,040,866,984.95
213404	Тоног төхөөрөмж	0.00	7,040,866,984.95
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙГЭЭ (VI)=(IV)-(V)		(7,040,866,984.95)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	58,141,841.67
14	Бусад эх үүсвэр	0.00	58,141,841.67
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	58,141,841.67
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	11,913,081,232.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	10.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	11,913,081,232.30

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	19,004,035,857.25	19,004,035,857.25
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	19,004,035,857.25	19,004,035,857.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,726,155,100.00	7,244,896,715.98	7,481,258,384.02	49.2
УРСГАЛ ЗАРДАЛ	1,409,235,000.00	204,029,731.03	1,205,205,268.97	14.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,409,235,000.00	204,029,731.03	1,205,205,268.97	14.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	187,819,000.00	39,199,047.62	148,619,952.38	20.9
Үндсэн цалин	187,819,000.00	39,199,047.62	148,619,952.38	20.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,802,000.00	4,899,880.95	19,902,119.05	19.8
Эрүүл мэндийн даатгал	24,802,000.00	4,899,880.95	19,902,119.05	19.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,130,000.00	0.00	11,130,000.00	0.0
Байрны түрээс	11,130,000.00	0.00	11,130,000.00	0.0
Хангамж, бараа материалын зардал	95,915,000.00	14,293,638.18	81,621,361.82	14.9
Бичиг хэрэг	14,442,000.00	2,517,300.00	11,924,700.00	17.4
Тээвэр, шатахуун	12,925,000.00	1,437,030.00	11,487,970.00	11.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,169,000.00	7,371,208.18	6,797,791.82	52.0
Ном, хэвлэл	41,600,000.00	1,850,000.00	39,750,000.00	4.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,779,000.00	1,118,100.00	11,660,900.00	8.7
Эд хогшил, урсгал засварын зардал	95,220,000.00	45,387,640.00	49,832,360.00	47.7
Багаж, техник, хэрэгсэл	80,000,000.00	44,989,940.00	35,010,060.00	56.2
Тавилга	15,220,000.00	397,700.00	14,822,300.00	2.6
Томилолт, зочны зардал	38,415,000.00	0.00	38,415,000.00	0.0
Дотоод албан томилолт	38,415,000.00	0.00	38,415,000.00	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	950,000,000.00	100,249,524.28	849,750,475.72	10.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	950,000,000.00	99,886,640.00	850,113,360.00	10.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	362,884.28	(362,884.28)	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	5,934,000.00	0.00	5,934,000.00	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	5,934,000.00	0.00	5,934,000.00	0.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,316,920,100.00	7,040,866,984.95	6,276,053,115.05	52.9
Тоног төхөөрөмж	13,316,920,100.00	7,040,866,984.95	6,276,053,115.05	52.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,726,155,100.00	19,027,047,535.25	(4,550,892,435.25)	129.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,476,155,100.00	19,027,047,535.25	(4,550,892,435.25)	129.2

“Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,744,695.84	(2,744,695.84)	0.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,476,155,100.00	19,024,302,839.41	(4,548,147,739.41)	131.4
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	250,000,000.00	72,788,571.36	177,211,428.64	29.1
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	250,000,000.00	72,788,571.36	177,211,428.64	29.1
БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	11,913,081,232.30	11,913,081,232.30	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	4	3	1	75.0
Удирдах ажилтан	0	0	0	0.0
Гүйцэтгэх ажилтан	4	3	1	75.0
Үйлчлэх ажилтан	0	0	0	0.0
Гэрээт ажилтан	0	0	0	0.0

Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төслийн зохицуулагч С.Энхболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагналыг дүрэм журмын дагуу үнэн зөв толилуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Интер Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, ахлах аудитор С.Уртнасан, аудитор Б.Гомбо нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2021 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 03 тоот албан бичгээр Интер Аудит ХХК-д хүргүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төслийн зорилго нь Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах Монгол Улсад чадавхыг бэхжүүлэх нийгмийн эрүүл мэндийн цаашдын яаралтай тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг сайжруулахад оршино.

Төслийн санхүүжилтийн болон зээлийн хэлэлцээр 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хурлаар соёрхон батлагдаж, төсөл хэрэгжүүлэгч нэгж байгуулагдсан.

Төслийн удирдах хороо 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар төслийн 2020 болон 2021 оны үйл ажиллагааны, худалдан авалтын болон төсвийн төлөвлөгөөнүүдийг баталсан байна.

Төслийн хүрээнд хийх ажил:

1. Нийслэлийн эх хүүхдийн 300 ортой эмнэлэг,
2. АШУҮИС-ийн дэргэдэх сургалтын эмнэлэг,
3. Улсын гуравдугаар төв эмнэлэг (Мэдрэлийн тасаг)
4. Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн нэгдсэн эмнэлгүүдийг нийт 1,000 орчим нэр төрлийн 11,500 гаруй эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл болон хувийн хамгаалах хэрэгслээр хангана.

Мөн КОВИД-19 халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах, хязгаарлах, нийгмийн эрүүл мэндийн цаашдын яаралтай тусламж, үйлчилгээний бэлэн байдлын чадавх болон хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

Уг төсөл нь 2020-2023 онд хэрэгжих бөгөөд Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр нийт 26.9 сая ам.долларын санхүүжилтийг дараах бүрэлдэхүүн хэсгүүдэд зарцуулахаар батлагдсан байна. Үүнд:

1. КОВИД-19 халдвараас яаралтай урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ авах – 2.5 сая ам доллар,
2. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чадавхыг бэхжүүлэх – 23.75 ам доллар,

3. Төслийн удирдлага, хяналт-шинжилгээ ба үнэлгээ - 0.65 ам доллар,
4. Онцгой байдалд яаралтай хариу арга хэмжээ авах – (нэмэлт санхүүжилт авах эсвэл төсвийн тодотгол хийсэн нөхцөлд ашиглагдана)

Нийт 23.75 сая ам.долларын эмнэлгийн тоног төхөөрөмжөөс 6.8 сая ам.долларын өртөгтэй 205 амьсгалын аппарат, 0.8 сая ам. долларын ларингоскоп нийлүүлэх гэрээнүүд байгуулагдаж, 2.08 сая ам.долларын үнийн дүн бүхий зөөврийн рентген аппарат, 4D эхо аппарат болон хувийн хамгаалах хэрэгсэл нийлүүлэх гэрээнүүд хэлэлцээрийн шатандаа явж байна.

Мөн КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх зорилгын хүрээнд эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүд, Гаалийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газрын албан хаагчдыг амны хаалт, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодис болон бусад хэмжилтийн багажаар хангах чиглэлээр Дэлхийн банкнаас Цар тахлын онцгой нөхцөлд өгөх санхүүжилтийн хүрээнд 1.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтийн төслийг боловсруулан Дэлхийн банканд хүргүүлж, батлуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 114 дүгээр тогтоол “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай”
- “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

“Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд санхүүгийн тайлангаа гаргахдаа 2007 онд Сангийн сайдын 326 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, УСНББОУС, Дэлхийн Банкны Санхүүгийн гарын авлагыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох эрх бүхий байгууллагаас хөндлөнгийн хяналт, шалгалт хийгээгүй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлан дахь хөрөнгө оруулалтын зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны мөнгөн гүйлгээний тайлан дахь хөрөнгө оруулалтын зардлын 7,244,896.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 144,897.9 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 19,004,035.9 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	11,913,081.2	11,913,081.2
Авлага	0.0	5,343.2	5,343.2
Урьдчилгаа	0.0	7,040,866.9	7,040,866.9
Бараа материал	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгө	0.0	44,744.4	44,744.4
Нийт хөрөнгө	0.0	19,004,035.9	19,004,035.9
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0.0	19,004,035.9	19,004,035.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	0.0	19,004,035.9	19,004,035.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 11,913,081.2 мянган төгрөг байгаа нь тайлант оны төлөвлөгөөт ажил 22.4 хувийн гүйцэтгэлтэй холбоотой байна.

Урьдчилгаа данс 7,040,866.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тайлант хугацаанд гэрээний дагуу гүйцэтгэгч талуудад урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 44,744.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тайлант онд компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Засгийн газрын оролцоо данс 19,004,035.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тайлант онд төлөвлөсөн худалдан авах ажиллагааны нийт 76 ажлаас 17 ажлын гэрээ байгуулж эхэлсэн бөгөөд үлдсэн 59 ажил хийгдээгүйн улмаас зарцуулалт бага гарсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 14,726,155.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 14,726,155.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 14,476,155.1 мянган төгрөгийг гадаад эх үүсвэрээс, 250,000.0 мянган төгрөгийг тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр гадаад эх үүсвэрээс 19,097,091.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 2,744.7 мянган төгрөг, нийт 19,099,836.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 204,029.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 49.2 хувьтай байгаа нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 76 ажлаас 59 ажил хийгдээгүйтэй холбоотой байна. Тайлант онд нийт 17 ажлын 7,040,866.9 мянган төгрөгийн урьдчилгааг төлбөр хийгдсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 94 мэдээллээс 34 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг орхигдуулсан байна.

3.8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4 алдаа зөрчил илэрснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

“Монгол улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн 2020 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах 94 мэдээллээс 34 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна..

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар санхүүгийн программ хангамж, худалдан авах ажиллагаа төлөвлөгөө ба биелэлт, худалдан авах ажиллагааны процесстой холбоотой 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.9. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Тиймээс дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, мөн өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

“Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн тайлант хугацаанд нийт 76 худалдан ажиллагаа төлөвлөсөн бөгөөд үүнээс 17 ажил хийгдэж 22.4 хувийн хэрэгжилттэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ул үндэслэлтэй, судалгаатай хийгээгүйн улмаас төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж төсөл хэрэгжүүлэгч нэгж хангалтгүй үнэлгээ авах, цаашид төслийн үйл ажиллагаа зогсох.

1.3. Өгсөн зөвлөмж:

Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг судалгаа, шинжилгээний үндсэн дээр боловсруулж, гүйцэтгэлд анхаарч ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

2. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.21-д заасан төсөл хэрэгжүүлэгч” гэж заасны дагуу тус төслийн нэгж нь уг хуулийн 21 дүгээр зүйл “Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх”, 21.1-д “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл:

Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим алдагдах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээллэх мөн холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3. Санхүүгийн программ хангамжтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тус төслийн нэгж нь нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программ ашигладаггүй бөгөөд санхүүгийн тайлан болон бусад тайлангуудыг эксэл файлаар хөтлөн явуулдаг байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй болохыг харуулж байна.

3.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланг бэлтгэхэд тооцооллын алдаа гарах, үнэн зөв толилуулагдахгүй байх, найдвартай байдал алдагдах.

3.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль, дүрэм, журам, олон улсын стандартад нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэн гаргаж, эрх бүхий байгууллагын тавигдах шаардлагад нийцсэн санхүүгийн программ хэрэглэх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/111/79/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	“Монгол улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 94 мэдээллээс 34 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг орхигдуулсан байна.	-	Албан шаардлага	Санхүүгийн ажилтан, Худалдан авах ажиллагааны ажилтан	П.Сувд, Ж.Энхжаргал
2	“Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн тайлант хугацаанд нийт 76 худалдан ажиллагаа төлөвлөсөн бөгөөд үүнээс 17 ажил хийгдэж 22.4 хувийн хэрэгжилттэй байна.	-	Зөвлөмж	Худалдан авах ажиллагааны ажилтан	Ж.Энхжаргал
3	“Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж	Худалдан авах ажиллагааны ажилтан	Ж.Энхжаргал
4	Тус төслийн нэгж нь нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программ ашигладаггүй бөгөөд санхүүгийн тайлан болон бусад тайлангуудыг эксэл файлаар хөтлөн явуулж байна.	-	Зөвлөмж	Санхүүгийн ажилтан	П.Сувд
	Нийт дүн	-			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 213/АД/70078

САГ-2021/11/79/СТА-ТХН

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Монгол улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах" төслийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Монгол улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах" төслийн 2020 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах 94 мэдээллээс 34 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг үнэн зөв, ил тод, хугацаанд нь байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллахыг "Монгол улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах" төслийн санхүүгийн ажилтан П.Сувдад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

ИНТЕР АУДИТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

Ч.МӨНХБАЯР

